2024 оны 08 сарын 14 өдөр

Дугаар 4/63

Улаанбаатар хот

Нөөцийг хүлээн авч, бүртгэх тухай


Засгийн газрын Агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх хэсэг, Ашигт малтмалын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.4 дэх хэсэг, Уул уурхай, хүнд үйлдвэрийн сайдын 2016 оны 23 дугаар тушаалаар батлагдсан Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн дүрмийн 3.1 дэх хэсэг, Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 07 дугаар сарын 25-ны өдрийн хуралдааны ХХ-13-17 дугаар дүгнэлтийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Ховд аймгийн Алтай сумын нутагт орших XV-019692 дугаартай тусгай зөвшөөрлийн талбайд хамаарах “Оцог хад” нэртэй гянтболдын үндсэн ордын нөөцийг зохиогчийн тооцоолсон хувилбараар хүснэгт №1-ийн дагуу хүлээн авсугай.

2. Хүлээн авсан гянтболдын нөөцийг ашигт малтмалын нөөцийн Улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгэхийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төв /Г.Золсайхан/-д зөвшөөрсүгэй.

3. Ховд аймгийн Алтай сумын нутаг дахь “Оцог хад” нэртэй гянтболдын үндсэн ордод 2016 онд гүйцэтгэсэн хайгуулын ажлын үр дүнгийн тайланг, тайлангийн бичвэр дискийн хамт ЭБМЗ-ийн хуралдааны дүгнэлт, тушаалыг хүлээн авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвийн архивт хүлээлгэн өгөхийг “Талст молор” ХХК /Б.Мөнхтөр/-д даалгасугай.

ДАРГА



Б.БААТАРЦОГТ

10 0992



УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН ЯАМ
АШИГТ МАЛТМАЛ, ГАЗРЫН ТОСНЫ ГАЗАР
ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН ЗӨВЛӨЛИЙН
ДҮГНЭЛТ

2018 оны 05 сарын 16 өдөр

Дугаар Т/18-06-05

Улаанбаатар хот

Ховд аймгийн Алтай сумын нутагт орших
MV-020930 тоот ашиглалтын тусгай
зөвшөөрөлтэй “Оцог хад” нэртэй
гянтболдын үндсэн ордыг далд уурхайн
аргаар ашиглах төслийн техник-эдийн
засгийн үндэслэлийг хэлэлцсэн тухай

“Талст молор” ХХК-ийн захиалгаар Уул уурхайн зураг төслийн “Жи Эм
проект” ХХК боловсруулсан Ховд аймгийн Алтай сумын нутагт орших “Оцог хад”
нэртэй гянтболдын үндсэн ордыг далд аргаар ашиглах төслийн техник-эдийн
засгийн үндэслэлд Монгол улсын зөвлөх инженер П.Хангал зөвлөж, Монгол Улсын
зөвлөх инженер Б.Магванжав шинжээчийн дүгнэлт гаргасан байна. Техник-эдийн
засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн ТЭЗҮ хэлэлцэх салбар
хуралдаанаар авч хэлэлцэж, дараах ДҮГНЭЛТ-ийг гаргаж байна.

1. Техник-эдийн засгийн үндэслэл нь Төслийн техник-эдийн засгийн үндэслэлийн
танилцуулга, Ордын геологийн судалгаа, далд уурхайн нээлт, Үйлдвэрлэлийн нөөц,
Олборлолт, Уурхайн засвар механик, Хүний нөөц, Дэд бүтэц, Хөдөлмөрийн аюулгүй
байдал, эрүүл ахуй, Байгаль орчин, Төслийн эдийн засаг зэрэг 13 бүлэг, дүгнэлт,
хавсралт материал, хавсралт тооцоо бүхий 170 хуудас тайлбар бичиг, хавсралт 10
зургуудаас бүрдэж байна.

2. MV-020930 тоот тусгай зөвшөөрлийн талбайн “Оцог хад” нэртэй гянтболдын
үндсэн ордын нөөцийг Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн 2017 оны 07 дугаар
сарын 25-ны өдрийн хурлын ХХ-13-17 тоот дүгнэлтийг үндэслэн гаргасан АМГ-ын
даргын 2017 оны 08 дугаар сарын 17-ны өдрийн н/63 дугаар тушаалаар бодитой В
зэргээр 40943.763 тн гянтболдын хүдэр, 147.4 тн металл, боломжтой (С) зэргээр
64172.995 тн гянтболдын хүдэр, 312.51 тн металл бөгөөд нийт (В+С) зэргээр
105116.76 тн гянтболдын хүдэр, 459.91 тн металл гэж нөөцийг ашигт малтмалын
нөөцийн улсын нэгдсэн тоо бүртгэлд бүртгүүлсэн байна.

3. Төсөлд үйлдвэрлэлийн нөөцийг бодохдоо ашиглалтын үеийн бохирдлыг
15.6%-аар, хаягдалыг 24.63%-аар тус тус авч тооцсон ба ордыг 3 жилийн хугацаанд
ашиглах бөгөөд энэ хугацаанд 115291.0 м³ уулын цул нурааж, магадласан В
үйлдвэрлэлийн нөөцөд шилжүүлэн 93874.56 м³ хүдэр олборлохоор төлөвлөсөн
байна. Жилийн хүчин чадал 34.0 мян.м³ хүдэр байна.

4. “Оцог хад” нэртэй гянтболдын үндсэн ордыг ашиглахад эдийн засгийн үр ашигтай
нөөцөд тулгуурлан далд уурхайн зардал, бүтээгдэхүүн борлуулах үнийг
14000 ам.доллар буюу 33.6 сая.төг-өөр борлуулах эдийн засгийн тооцоог хийж
ТЭЗҮ-ийг боловсруулсан байна.

5. Уурхайн ашиглалтын системийн сонголтыг хийхдээ ордын геологийн тогтоц
болон байршил, хүдрийн биетийн унал, хүдрийн биетийн дундаж зузаан, уурхайн
олборлолтод өртөх нөөцийн доод хил, чулуулгийн шинж чанар, хүдрийн биетийн

000567

сунал ба уналын дагуу хувиралт өөрчлөлт багатай, тасралт эвдрэл бага зэргийг харгалзан үзэж хүдэр хоршоолох ашиглалтын системээр ашиглах нь оновчтой гэж үзжээ.

6. Уурхайд дугуйт ачигч LIUGONG 1ш, тээврийн машин /пад/ TYP1450-12D 3ш, далд уурхайн ачигч JHLTW60 2ш, перфоратор 765D 5ш, перфоратор YSP-45 3ш, ус таталын насос ЦНС-38-176 2ш, ЗМК-1А шпур цэнэглэх машин 1ш, усалгааны машин 1ш, худгийн насос 1ш, тэсэлгээний аппарат 1ш, ачааны машин Foton 1ш, цахилгаан генератор DCA-125K 1ш зэрэг үндсэн тоног төхөөрөмжүүдийг ашиглахаар ТЭЗҮ-д тусгажээ.

7. Ордын хүдрийн баяжигдах шинж чанарын судалгаа “Геологийн төв лаборатори”-д хийгдсэн байна. Туршилтын ажлыг “Талст молор” ХХК-ийн Ховд аймгийн Алтай сумын нутагт орших “Оцог хад” нэртэй гянтболдын үндсэн ордоос авсан 350 кг дээжинд хийсэн байна. Технологийн туршилтын ажлыг гравитацийн аргаар хийж гүйцэтгэсэн ба үр дүнд 65.86%-ийн агуулгатай, 81.56%-ийн металл авалттай, 0.47%-ийн гарцтай баяжмал гарган авч болно гэж үзсэн байна.

8. Олборлолтын явцад техникийн болон биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг Монгол улсын стандарт зааварчилгааны дагуу гүйцэтгэж, уулын ажлын үр дүнд үүссэн ухашийг нөхөн дүүргэж тэгшлэх, тухайн бүсийн уур амьсгалын нөхцөл байдалд тохирсон мод, бутлаг ургамлаар биологийн нөхөн сэргээлтийн ажлуудыг хийж гүйцэтгэхээр зардлыг төсөлд тусгасан байна.

9. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээлт ба хаалтын зардалд нийт 68.92 сая төгрөг зарцуулахаар тооцсон байна. Үүнээс байгаль орчин хамгаалах зардалд 7.5 сая.төгрөг, техникийн нөхөн сэргээлтийн зардалд 37.9 сая төгрөг, биологийн нөхөн сэргээлтийн зардалд 23.52 сая.төгрөг, төслийн хаалтын зардалд 64.02 сая.төгрөг зарцуулахаар тусгажээ.

10. Уурхайн нийт хөрөнгө оруулалтын хэмжээ 567.24 тэрбум төгрөг ба төслийн нийт хугацаанд 9.659 тэрбум төгрөгийн борлуулалтын орлого олж, 7.893 тэрбум төгрөгийн зардал гарган, 1.554 тэрбум төгрөгийн цэвэр ашиг олж, хөрөнгө оруулалтаа ашиглалтын 1.61 жилийн хугацаанд нөхөхөөр тооцжээ.

11. Төслийн хугацаанд нийт 1.366 тэрбум төгрөгийн үйл ажиллагааны мөнгөн урсгал бий болох бөгөөд хорогдуулалтын норм тооцсон өнөөгийн цэвэр үнэ цэнэ NPV (10%)=545.6 сая.төг, NPV (15%)=393.4 сая.төг, NPV (20%)=272.8 сая.төг, өгөөжийн дотоод норм 39% гарсан нь төсөл эдийн засгийн хувьд үр ашигтайгаар хэрэгжих боломжтой гэж үзжээ.

12. Төсөл хэрэгжсэнээр улс, орон нутгийн төсөвт 1.774 тэрбум төгрөгийг татвар төлбөр хэлбэрээр төвлөрүүлэх ба 71 хүний ажлын байр шинээр бий болохоор төсөлд тусгажээ.

13. Төсөлд шаардлагатай мэргэжлээр Монгол улсын иргэдийг бэлтгэх, тэдгээрийг ажлын байраар хангах, нийгмийн асуудлыг шийдвэрлэх, нийгмийн өмнө хүлээсэн үүргээ биелүүлж байгаль орчныг нөхөн сэргээх, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн талаар холбогдох байгууллагуудтай хамтран ажиллаж байхыг ЭБМЗ-өөс даалгаж байна.

14. Техник, эдийн засгийн үндэслэл нь уншихад ойлгомжтой, цэгц дараалал сайтай, мэргэжлийн түвшинд чанартай сайн боловсруулсан, уурхайг эхлэн байгуулж үйлдвэрлэл явуулах бүхий л шат дамжлага буюу үйл ажиллагааг хамарсан, уулын ажлын төлөвлөгөө боловсруулах зэрэгт туслах үндсэн баримт бичиг болжээ.

15. Хөдөрмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн стандарт, дүрэм журмуудыг чанд мөрдөж ажиллах мөн ашигт малтмалын нөөц ашигласны төлбөрийг улсад

хохиролгүйгээр борлуулалтын гэрээнд тусгаж ажиллахыг “Талст молор” ХХК-нд зөвлөмж болгов.

16. Энэхүү техник, эдийн засгийн үндэслэл нь ЭБЭХ-ийн сайдын 2012 оны 04 дүгээр сарын 17-ны өдрийн 074-р тушаалаар баталсан “Ашигт малтмалын баялгийн урьдчилсан үнэлгээ, ашигт малтмалын ордын нөөцийг ашиглах боломжийн урьдчилсан үнэлгээ, уул уурхайн төслийн техник, эдийн засгийн үндэслэлд тавигдах үндсэн шаардлагууд ба техник, эдийн засгийн үндэслэл хүлээн авах журам”-ын дагуу гүйцэтгэгдсэн байна гэж үзлээ.

17. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгагдсан техник, технологийн сонголт, уулын ажлын төлөвлөлт, цахилгаан болон усан хангамж, дэд бүтэц, байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээлт, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, төслийн эдийн засгийн үнэлгээг боловсруулсан Уул уурхайн зураг төслийн “Жи Эм прожект” ХХК хариуцах, түүний үнэн бодит байдал, чанарт гаргасан дүгнэлтийг шинжээч Монгол улсын зөвлөх инженер Б.Магванжав хариуцах.

18. Техник-эдийн засгийн үндэслэлд тусгасан уурхайн хүчин чадал, техник тоног төхөөрөмж, технологи, эдийн засгийн тооцоог өөрчлөх тохиолдолд уг техник-эдийн засгийн үндэслэлд тодотгол хийлгэж, ЭБМЗ-ийн салбар хуралдаанаар хэлэлцүүлж байх нь зүйтэй.

19. Захиалагч компани Техник-эдийн засгийн үндэслэлийг хүлээн авах тухай Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын шийдвэр гарснаас хойш 5 хоногт багтаан Техник-эдийн засгийн үндэслэлийг Эрдэс баялгийн мэдээллийн технологийн төвд холбогдох шаардлагад нийцүүлэн хүлээлгэн өгөх үүрэгтэй. Энэ үүргээ хэрэгжүүлээгүй тохиолдолд Геологи, уул уурхайн асуудал эрхэлсэн Төрийн захиргааны байгууллагын дарга гаргасан шийдвэрээ түдгэлзүүлэх, цуцлах эрхтэйг анхааруулах нь зүйтэй.

Техник-эдийн засгийн үндэслэлд хийсэн шинжээчийн дүгнэлт, зөвлөлийн гишүүдийн саналыг үндэслэн Эрдэс баялгийн мэргэжлийн зөвлөлийн Салбар хуралдаанаас Ашигт малтмал, газрын тосны газрын даргад Ашигт малтмалын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.4, 48 дугаар зүйлийн 48.4, Газрын хэвлийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгүүд болон энэ дүгнэлт, холбогдох хуулийн заалтуудыг тус тус үндэслэн “Ховд аймгийн Алтай сумын нутагт орших MV-020930 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөлтэй “Оцог хад” нэртэй гянтболдын үндсэн ордыг далд уурхайн аргаар ашиглах төслийн техник-эдийн засгийн үндэслэл”-ийг хүлээн авах шийдвэр гаргахыг уламжлахаар шийдвэрлэв.

ТАНИЛЦСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ДЭЛГЭРЖАРГАЛ

ХУРАЛДААНЫГ УДИРДСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР
ЗӨВЛӨЛИЙН ДАРГА

Б.ЭЛБЭГЗАЯА

БОЛОВСРУУЛСАН:

ЭРДЭС БАЯЛГИЙН МЭРГЭЖЛИЙН
ЗӨВЛӨЛИЙН САЛБАР ЗӨВЛӨЛИЙН
НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.ГАН-ОЧИР

“ОЦОГ ХАД” ГЯНТБОЛДЫН
ҮНДСЭН ОРД

15:13

5G

<

AA

-Шилжүүлгийн мэдээлэл-Банк дотор

T

Худалдаа Хөгжлийн Банк

27 Oct

☆

To: URANCHIMEG9@YAHOO.COM

Худалдаа Хөгжлийн Банк

Огноо: 2025.10.27 13:49:19

Шилжүүлгийн мэдээлэл

Журналын №: 290053575

Системийн огноо: 2025.10.27

Нэр: ТАЛСТМОЛОР ХХК

Илгээгч	Дансны дугаар:	Нэр	Дүн	Ханш
	474061996	ТАЛСТМОЛОР ХХК	960,000.00 MNT	1.00
/ есөн зуун жаран мянган төгрөг /				
Хүлээн авагч	Банкны дугаар:	Банкны нэр		
	040000	Худалдаа Хөгжлийн Банк	960,000.00 MNT	1.00
	Дансны дугаар	Нэр		

Гүйлгээний утга:
EB -2251005132433-Хог хаягдлын үйлчилгээний хураамж-Ховд

Танд баярлалаа

Гүйлгээний баримтыг баталгаажуулсан
Салбар, тооцооны төв:
Гарын үсэг:

Тамга:

Огноо: _____ Он ____ Сар ____ Өдөр

Delete

Reply

Forward

Move

More

Хог хаягдалын хураамж төлбөрийн баримт

“ТАЛСТ МОЛОР” ХХК

“ОЦОГ ХАД” ГЯНТБОЛДЫН
ҮНДСЭН ОРД

40

16:41

Done itax.mta.mn

 **ТАТВАР ТӨЛСӨН БАРИМТ № -
2251200569157**

ТТД /	37900824131 / 9068007
Регистр:	
Татвар	Ховд аймгийн Үенч сумын засаг
төлөгчийн	даргын тамгын газар
нэр:	
Татварын	01030708 - Ахуйн хэрэглээний ус,
төрөл:	рашаан ашигласны төлбөр
Харъяалах	Ховд / Үенч
татварын	
алба:	
Төлсөн дүн:	4,015,616.00
Гүйлгээний	2025-12-05 16:40:12
огноо:	
Гүйлгээний	2251200569157 33101528539 Ховд
утга:	аймгийн Үенч сумын засаг даргын
	тамгын газар;ХУДАЛДАА
	ХӨГЖЛИЙН БАНК;О
Татварын	100161200944 / Хо.Үе Ус, рашааны
данс:	төлбөр
Төлөлтийн	MOST
хэлбэр:	



Ус рашааны төлбөр төлсөн баримт

 **МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**
Төлбөрийн баримтын дугаар: 1250219218492

ТТД/Регистр: 5774047
Татвар төлөгчийн нэр: Талстмолор
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харьяалах татварын алба: Ховд
Төлсөн дүн: 8,908.00 ₮
Гүйлгээний огноо: 2025-05-23 16:47:42
Гүйлгээний утга: 1250219218492 33101528539 Талстмолор
474061996ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНҚО

 **МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**
Төлбөрийн баримтын дугаар: 1250219081734

ТТД/Регистр: 5774047
Татвар төлөгчийн нэр: Талстмолор
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харьяалах татварын алба: Ховд
Төлсөн дүн: 3,560.00 ₮
Гүйлгээний огноо: 2025-05-23 16:47:34
Гүйлгээний утга: 1250219081734 33101528539 Талстмолор
474061996ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНҚО

 **МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**
Төлбөрийн баримтын дугаар: 1250219020732

ТТД/Регистр: 5774047
Татвар төлөгчийн нэр: Талстмолор
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харьяалах татварын алба: Ховд
Төлсөн дүн: 3,564.00 ₮
Гүйлгээний огноо: 2025-05-23 16:48:00
Гүйлгээний утга: 1250219020732 33101528539 Талстмолор
474061996ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНҚО

 **МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**
Төлбөрийн баримтын дугаар: 1250219017894

ТТД/Регистр: 5774047
Татвар төлөгчийн нэр: Талстмолор
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харьяалах татварын алба: Ховд
Төлсөн дүн: 3,560.00 ₮
Гүйлгээний огноо: 2025-05-23 16:47:38
Гүйлгээний утга: 1250219017894 33101528539 Талстмолор
474061996ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНҚО


 **МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**
Төлбөрийн баримтын дугаар: 1250219061595

ТТД/Регистр: 5774047
Татвар төлөгчийн нэр: Талстмолор
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харьяалах татварын алба: Ховд
Төлсөн дүн: 64,582.00 ₮
Гүйлгээний огноо: 2025-05-23 16:47:49
Гүйлгээний утга: 1250219061595 33101528539 Талстмолор
474061996ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНҚО

 **МОНГОЛЫН ТАТВАРЫН АЛБА**
Төлбөрийн баримтын дугаар: 1250219025897

ТТД/Регистр: 5774047
Татвар төлөгчийн нэр: Талстмолор
Татварын төрөл: 01030731 - Газрын төлбөр-Дэд алба
Харьяалах татварын алба: Ховд
Төлсөн дүн: 21,688.00 ₮
Гүйлгээний огноо: 2025-05-23 16:47:57
Гүйлгээний утга: 1250219025897 33101528539 Талстмолор
474061996ХУДАЛДАА ХӨГЖЛИЙН БАНҚО

Газар ашигласаны төлбөр төлсөн баримт



Аюултай хог хаягдал болон ахуйн хогийг ангилан ялгах агуулахын зураг

ХОВД АЙМГИЙН АЛТАЙ СУМЫН
ЗАСАГ ДАРГЫН ХАТАНБААТАР

БАТЛАВ:

“ТАЛСТ МОЛОР” ХХК-ИЙН
ЗАХИРАЛ Б.МӨНХТӨР

ХОГ ХАЯГДЛЫН ГЭРЭЭ

2025.05.20 Алтай сум

Гэрээний зорилго:

Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийг хэрэгжүүлж хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх хортой нөлөөллийг арилгах, түүнээс урьдчилан сэргийлэх зорилгоор хог хаягдлыг дахин боловсруулах ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, эргүүлэн ашиглах, устгах зорилготой.

Гэрээний эрх зүйн үндэслэл:

-Монгол улсын Хог хаягдлын тухай хууль
-Монгол улсын Ариун цэврийн тухай хууль

Гэрээ байгуулагч талууд:

Нэг талаас Ховд аймгийн Алтай сумын Засаг даргын Тамгын газрыг төлөөлж Байгаль орчны хяналтын улсын байцаагч Б.Мөнхцэцэг, нөгөө талаас “Талст молор” ХХК-ийн “Оцог хад” уурхайн дарга Х.Баатаржав нар тохиролцож 2025 оны 05 дугаар сарын 20-ний өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ийг хүртэлх хугацаагаар энэхүү гэрээг байгуулав.

Нэг. ААН байгууллагын эрх үүрэг

1.Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн 10 дугаар зүйл, 20 дүгээр зүйлийн заалт, Алтай сумын ИТХ-ын 2021 оны 08 дугаар сарын 23-ны өдрийн 3 дугаар хуралдааны 3/05 дугаар тогтоолыг үндэслэн хог хаягдал гаргасны төлбөрт жилд 960.000 төгрөгийг Алтай сумын татварын орлогын 100160100947 тоот дансанд 2025 оны 12 дугаар сарын 31-ны дотор төвлөрүүлэх.

2.ААН, байгууллага өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хогийг тогтсон хугацаанд цэвэрлэх, тээвэрлэх, хог хаягдлын талаарх дүрэм журам, стандартын шаардлагыг хангаж, зориулалтын цэгт хаяж байх.

3.Аюултай хог хаягдлыг аюултай хог хаягдлын төвлөрсөн байгууламж эсвэл тогтоосон цэгт зөөн тээвэрлэж булшлах.

4.Үйл ажиллагааны явцад үүсдэг хог хаягдлын хэмжээ түүний тухай мэдээллийг сумын Засаг даргын Тамгын газарт үнэн зөв мэдээлж байх.

5.Хог хаягдлыг ангилан хаях талаар зохих мэдээллийг ажилтнууддаа эзэмшүүлж, аюулгүй ажиллагааны шаардлагыг ханган ажиллах

Хоёр: Сумын ЗДТГ-ын эрх үүрэг

1.Нутаг дэвсгэрийн хэмжээнд Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх

2.Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих

3.Монгол улсын Хог хаягдлын тухай хуулийн 20 дугаар зүйлийг үндэслэн ААН, байгууллагаас хог хаядал гаргасан төлбөр нэхэмжлэх

4.Хуулиар олгогдсон эрхийн дагуу ААН, байгууллага өөрийн ахуйн болон үйлдвэрлэлийн хог хаягдлын хэмжээний талаар өгч буй мэдээлэл, орчны ариун цэврийн байдалд хяналт тавих эрхтэй.

5.Хог хаягдлыг ил асгах, орчин тойрныг бохирдуулах, ариун цэврийн шаардлага хангаагүй нөхцөлд эрүүгийн хариуцлага хүлээлгэхгүйгээр Зөрчлийн тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн хүрээнд хариуцлага хүлээлгэнэ.

Гурав. Бусад

3.1.Гэрээ нь талууд гарын үсэг зурж тамга, тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

3.2.Гэрээний биелэлтийг тухай бүрд нь дүгнэнэ.

3.3.Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болно.

3.4.Талуудын хооронд үүссэн маргааныг эвийн журмаар шийдвэрлэхийг эрхэмлэх бөгөөд эс зөвшөөрвөл холбогдох шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

АЛТАЙ СУМЫН
БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН
УЛСЫН БАЙЦААГЧ  Б.МӨНХЦЭЦЭГ

УУРХАЙН ДАРГА  БААТАРЖАВ



Хог хаягдалын гэрээ

“ТАЛСТ МОЛОР” ХХК

“ОЦОГ ХАД” ГЯНТБОЛДЫН
ҮНДСЭН ОРД

2025 оны 12 сар 4-ны өдөр

Тус сумын Бодонч багийн нутагт ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг
“Талст Молор” ХХК-ны 2025 оны Байгаль орчныг хамгаалах менежмент төлөвлөгөөнд
тусгагдсан ажлын хүрээнд Булгийн эх хамгаалах ажлыг хийж гүйцэтгэсэн.

1. Алтай сумын Барлаг багийн нутагт орших “Бага хатуун ус”-н эхийг хашиж
хамгаалсан.

Төлөвлөгөөнд тусгагдсан булгийн эх хамгаалах ажлыг хугацаанд нь чанартай
гүйцэтгэж ажлын хэсэгт шалгуулан хүлээлгэн өгсөн болохыг гэрчилж энэхүү актыг
үйлдэв.

/зургийг хавсралтаар оруулав/

АКТ ГАРГАСАН:

Комиссийн дарга:

Алтай сумын Засаг даргын орлогч

Жишүүд: Алтай сумын БОХУБ

Үенч, Бодонч, Булган голын сав газрын

захиргааны БОХУБ

Н.Нандинцэцэг



ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

“Талст молор” ХХК-ийн

Уурхайн дарга:

Уулын инженер:



Х.Баатаржав

Х.Мөнхсайхан

Булгийн эх хамгаалсан акт


Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын
2023 оны 09 дүгээр сарын 06-ны өдрийн А/439
дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

ЭВДЭРСЭН ГАЗАРТ НӨХӨН СЭРГЭЭЛТ ХИЙСЭН ГАЗРЫГ ХҮЛЭЭЖ АВАХ АКТ

2025 оны 10 дугаар сарын 31-ний өдөр

1. Байршлын мэдээлэл		
1.1.	Аймаг, нийслэлийн нэр	Ховд
1.2.	Сум, дүүргийн нэр	Алтай сум, Бодонч баг
1.3.	Газрын нэр	Хөндийн хэв
2. Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын мэдээлэл		
2.1	Нөхөн сэргээлт хийсэн аж ахуй нэгжийн нэр, регистр	"Талст молор" ХХК РД:5774047
2.2	Хөрөнгийн хэмжээ, эх үүсвэр	"Талст молор" ХХК-ний "Оцог хад" гянтболдын уурхайг далд аргаар ашиглах төслийн 2025 оны байгаль орчны менежмент төлөвлөгөөний биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний хүрээнд буюу ашигт малтмалын ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшигчийн хөрөнгөөр
2.3	Тус газрын эвдрэлд өртсөн шалтгаан	Хууль бус үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон.
2.4	Тус талбайд нийт эвдрэлд өртсөн талбайн хэмжээ (га)	1 га
2.5	Газрын хэвлийн нөхөн сэргээлт хийх мэргэжлийн байгууллагын эрхтэй эсэх, зөвшөөрлийн дугаар	Үгүй
3. 2025 онд хүлээлгэн өгч буй нөхөн сэргээлтийн мэдээлэл		
Техникийн нөхөн сэргээлт Тухайн жилийн төлөвлөгөөнд туссаны дагуу зөвхөн техникийн нөхөн сэргээлт хийсэн. - Талбайн хэмжээ (га) -1 - Зардлын хэмжээ (төгрөгөөр)- 3.0 сая		Биологийн нөхөн сэргээлт - Талбайн хэмжээ (га) - Биологийн нөхөн сэргээлтэд ашигласан мод, сөөг, ургамлын зүйлийн нэр, ургамалжуулсан байдал - Зардлын хэмжээ (төгрөгөөр)
4. Орон зайн мэдээлэл		

4.1 Нөхөн сэргээлт хийгдсэн газрын фото зураг



4.2. Хэмжилт, зураглал

- Кадастрын зураглал хийсэн мэргэжлийн байгууллага болон хэмжилт хийсэн хүний нэр:
Б.Ариундолгор
- Хэмжилтэд ашигласан программ, тоног төхөөрөмж,
- ArcGIS 10.8
- GPS-Garmen 32
- Холбогдох утас: 94032727
Гарын үсэг:

4.3 Нөхөн сэргээлт хийсэн газрын солбицол

Жич: 4-өөс доошгүй эргэлтийн цэгийн солбицол байна.

№	Өргөрөг	Уртраг
Техникийн нөхөн сэргээлт		
1-р хэсэг		
1	46° 19' 2.730" N	92° 21' 49.130" E
2	46° 19' 2.513" N	92° 21' 50.172" E
3	46° 19' 1.151" N	92° 21' 50.312" E
4	46° 18' 59.890" N	92° 21' 50.252" E
5	46° 18' 59.690" N	92° 21' 49.170" E
6	46° 19' 1.349" N	92° 21' 49.094" E
7	46° 19' 2.730" N	92° 21' 49.130" E
2-р хэсэг		
1	46° 18' 59.030" N	92° 21' 51.380" E
2	46° 18' 58.993" N	92° 21' 52.560" E
3	46° 18' 58.333" N	92° 21' 52.241" E
4	46° 18' 58.362" N	92° 21' 51.862" E
5	46° 18' 58.441" N	92° 21' 51.312" E
6	46° 18' 59.030" N	92° 21' 51.380" E
3-р хэсэг		
1	46° 18' 37.480" N	92° 22' 17.240" E
2	46° 18' 38.060" N	92° 22' 17.986" E
3	46° 18' 35.990" N	92° 22' 22.760" E
4	46° 18' 35.650" N	92° 22' 21.970" E
5	46° 18' 34.860" N	92° 22' 22.130" E
6	46° 18' 31.931" N	92° 22' 19.615" E
7	46° 18' 32.240" N	92° 22' 19.190" E
8	46° 18' 35.620" N	92° 22' 20.800" E
9	46° 18' 37.480" N	92° 22' 17.240" E
4-р хэсэг		
1	46° 18' 46.060" N	92° 22' 2.010" E
2	46° 18' 46.457" N	92° 22' 2.675" E
3	46° 18' 45.905" N	92° 22' 3.547" E
4	46° 18' 44.901" N	92° 22' 4.208" E

5	46° 18' 44.258" N	92° 22' 2.959" E
6	46° 18' 44.701" N	92° 22' 2.360" E
7	46° 18' 46.060" N	92° 22' 2.010" E

Нөхөн сэргээлт хийсэн газарт хэмжилт хийж талбайн хэмжээг тогтоон полигон хэлбэрээр shape.file үүсгэн флаш болон CD-нд хуулж акттай хавсаргана.

5. Мэдээллийн сангийн бүртгэл

Нөхөн сэргээлтийг хүлээн авсан ажлын хэсэг нь Байгаль орчны мэдээллийн сангийн www.eis.mn цахим системийн Нөхөн сэргээлтийн мэдээллийн дэд санд заавал бүртгүүлнэ.

Мэдээлэл оруулсан хүний нэр, албан тушаал: Б.Ариундолгор, БОГ-ын мэргэжилтэн

Гарын үсэг:

Огноо:

Нэмэлт мэдээлэл:

Хууль бус ашигт малтмал олборлох үйл ажиллагааны улмаас эвдрэлд орж эзэнгүй орхигдсон.

Нөхөн сэргээлтийн ажил нь холбогдох хууль, журам, стандартад нийцсэн талаарх ажлын хэсгийн дүгнэлт:

Ажлын хэсгийн зүгээс тус газарт хийгдсэн нөхөн сэргээлтийн ажлыг стандартад нийцсэн гэж үзэж хүлээн авахаар шийдвэрлэлээ.

Эвдэрсэн газрын техникийн нөхөн сэргээлт хийсэн талбайд орон нутгийн захиргааны байгууллагаас хяналт тавьж, дахин олборлолт явуулахгүй байх, цаашид биологийн нөхөн сэргээлт хийлгэхэд анхаарч ажиллах шаардлагатай.

АКТ ГАРГАСАН:

Комиссын дарга:

Нарийн бичгийн дарга:

Ч.Нэргүй /Байгаль орчны газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч/

Б.Ариундолгор /Байгаль орчны газрын газар, газрын хэвлий, түүний баялагийн ашиглалт хамгаалалт, нөхөн сэргээлт хариуцсан мэргэжилтэн/

Гишүүд:

Б.Наранзул /Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газрын мэргэжилтэн/

Б.Мөнхцэцэг /Алтай сумын байгаль орчны хяналтын улсын байцаагч/

Э.Энхбаяр /Алтай сумын Бодонч багийн Засаг дарга/

ХҮЛЭЭН ЗӨВШӨӨРСӨН:

Б.Мөнхтөр /"Талст молор" ХХК-ний захирал/



нөхөн сэргээлт хийсэн талбайн хүлээлцсэн акт

БАТЛАВ
ҮЕНЧ БОДОНЧ БУЛГАН ГОЛЫН
САВ ГАЗРЫН ЗАХИРГААНЫ
ДАРГА.....Б.БАТЗОРИГ

БАТЛАВ
ТАЛСТ МОЛОР ХХК
ЗАХИРАЛ.....Б.МӨНХТӨР

УС АШИГЛУУЛАХ ГЭРЭЭ

2025 оны 10 дугаар сарын 16-ны өдөр Дугаар-1 Ховд аймаг Булган сум

Нэг. Ерөнхий зүйл

1.1 Усны тухай хуулийн 26.4, 26.6, 26.7,29,1-д заасны дагуу Ус ашиглуулагчийг төлөөлж сав газрын захиргааны Усны чанар, экологи төлбөрийн асуудал хариуцсан мэргэжилтэн Насанбат овогтой Нандинцэцэг, Ус ашиглагчийг төлөөлж Талст молор ХХК-ийн уурхайн дарга Ганболд овогтой Алтангэрэл нар Ховд аймаг Алтай суманд орших 9011444150 тоот улсын бүртгэлийн, 5774047 регистрийн дугаартай, MV-020930 тоот ашиглалтын тусгай зөвшөөрөл эзэмшдэг “ТАЛСТ МОЛОР” ХХК-ийн энэхүү гэрээг 1 жилийн хугацаатайгаар байгуулав.

1.2. Гэрээг монгол хэлээр 2% үйлдэж талуудад нэг нэг хувь хадгалагдах бөгөөд аль ч хувь нь хуулийн хүчинтэй баримт мөн.

1.3. Энэхүү гэрээнд тусгагдаагүй зүйлийг Монгол Улсын холбогдох хуулиар зохицуулна.

Хоёр. Гэрээний нөхцөл

2.1. Ус ашиглах зориулалт. Хүдрийг далд аргаар олборлон гянтболдыг гравтацийн аргаар баяжуулах зориулалтаар

2.2. Ашиглах усны хэмжээ, 33398.4 м³/жил

2.3. Тухайн сард ногдох төлбөрийг ус ашиглагч өөрөө тодорхойлж сар бүрийн 20-ны дотор Ховд аймгийн Төрийн сангийн орон нутгийн татварын дансанд товлорүүлнэ (Ховд аймгийн Үенч сумын Төрийн сангийн дансанд төлбөрийн 2025 оны жилийн эцсийн тооцоог 2026 оны 1 дүгээр сарын 10-ны дотор хийсэн байна.

2.4. Унд ахуй болон үйлдвэрлэлийн зориулалттай усны хэрэглээг Ховд аймгийн Үенч сумын Нүцгөний гол, Ховд аймгийн Алтай сумын Хөндийн голуудаас зөөврөөр авч ашиглана.

Ус ашиглуулах дүгнэлт дугаар E-2506-000223 -ийн дагуу ноогдуулсан нийт төлбөр : 8015616.00 төгрөг /Найман сая арван таван мянга зургаан зуун арван зургаан төгрөг/

2.5 Ус ашиглуулах дүгнэлтээр урьдчилсан байдлаар тооцсон төлбөрийн хэмжээ /3015616.00 төгрөг/ -ээс Ус ашиглуулах гэрээг дүгнэхдээ үйл ажиллагаа явуулсан гүйцэтгэлээр тооцож оруулна.

Гурав. Талуудын эрх, үүрэг, хариуцлага

3.1. Гэрээ байгуулагч талууд нь Усны тухай хуулийн 7.5, 10.1.10, 13.1.1, 13.1.5, 18.1.4, 19.1.2, 19.1.4, 26.1, 30.1, 30.2, 31.1.1 –д заасан эрх эдэлж үүрэг хүлээнэ.

3.2. Усны нөөц ашигласны төлбөрийг гэрээт хугацаандаа төлөөгүй тохиолдолд Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 25.3 дахь заалтыг үндэслэн хариуцлага хүлээлгэх болно.

3.3. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан ус ашиглах гэрээг Монгол улсын усны тухай хуулийн 29.3 дах заалтыг үндэслэн дараах тохиолдолд зөвшөөрөл олгогчийн санаачлагаар хугацаанаас нь өмнө цуцална.

3.3.1. Ус ашиглагчийн үүрэг болон гэрээнд заасан үүргээ бислүүлээгүй,

3.3.2 Байгаль орчныг хамгаалах тухай болон усны тухай хууль тогтоомж зөрчсөн,

3.3.3 Ус ашигласны болон бохирдуулсны төлбөрийг тогтоосон хугацаанд нь төлөөгүй,

3.3.4. Усны эх үүсвэрийг бохирдуулсан;

3.3.5. Усны тоолуур болон тохиргооны тоног төхөөрөмж суурилуулаагүй буюу ашигласан усны тооцоог хуурамчаар тооцсон;

3.3.6 Сав газрын захиргааны шийдвэрээр,

3.4. Ус ашиглагч нь мэргэжлийн усны менежертэй болох

3.5 Байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг 2022 онд багтаан хийлгүүлэх,

Дөрөв. Бусад

4.1. Гэрээ нь талууд гарын үсэг зурж, тамга тэмдэг дарж баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болно.

4.2. Ус ашиглуулах дүгнэлт, ус ашиглах зөвшөөрөл нь гэрээний салшгүй хэсэг байна.

4.3 Гэрээний биелэлтийг талууд 2026 оны 03-р сарын 10-ны дотор, дүгнэж протокол үйлдэнэ. Протоколд бодитоор хэрэглэсэн ус болон төлбөрийн мэдээллийг тодорхой тусгана.

4.4. Талуудын тохиролцсоноор гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулж болох ба бичгээр үйлдэнэ.

4.5. Иргэн аж ахуйн нэгж, байгууллагатай байгуулсан ус ашиглах гэрээг Монгол улсын усны тухай хуулийн 29.3 дах заалтыг үндэслэн дараах тохиолдолд зөвшөөрөл олгогчийн санаачлагаар хугацаанаас нь өмнө цуцалж болно.

4.6. Гэрээг биелүүлэх явцад үүссэн маргааныг талууд эв зүйгээр зохицуулах бөгөөд асуудлыг хэлэлцээрийн журмаар шийдвэрлэх боломжгүй тохиолдолд хариуцагчийн харъяах шүүхэд хандаж шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН ТАЛУУД:

Ус ашиглуулагч: Үенч-Бодонч-Булган голын сав газрын захиргаа Ховд аймаг Булган сум Далт баг

Усны чанар төлбөрийн асуудал хариусан
мэргэжилтэн: *Н.Нандинцэцэг*.....Н.Нандинцэцэг
Утас: 94003196, 99318321

Ус ашиглагч: Талст молор ХХК
Улаанбаатар хот, Баянзүрх дүүрэг, 18-р хороо, 13 –р хороолол, 1716, 13 тоот

Талст молор ХХК-ийн уурхайн
дарга: *Г.Алтангэрэл*.....Г.Алтангэрэл
Утас: 99040431